# СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Яам -ны ГТ-д тус-сан | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хугацаа | Хэрэг-жил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт** | | | | | | | | | |
| **Зорилт 1. Бүсчилэн хөгжүүлэх** | | | | | | | | | |
| 1 | 2.6.5 | Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх, соёлын аяллыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах **АХ 2050-1.2.7, 1.2.8, 4.2.47, 8.2.2, ЗГҮАХХАХТ -1.3.1.3, 3.3.5.2, 3.3.5.9, ССАЖЗЯ- СТ – 5.5** | - | Төлөвлөгөө -1 | Адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэх судалгаа хийгдсэн. | Төлөвлөгөө боловсруулсан байна. | "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг хангах хүрээнд бүсүүдийн нөөц, даац, онцлогт тулгуурлан орон нутгийн эдийн засгийг нэмэгдүүлэхүйц төлөвлөлт хийж, аялал жуулчлалын хөгжлийн орон зайн үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлалыг хийх, бүсийн зураг" хийх ажлыг МУИС-ийн харьяа Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэнтэй хамтран гүйцэтгэж байна. Хангайн бүсийн аялал жуулчлалын бүсчлэл, орон зайг хөгжүүлэхэд /Орхон голын Их хөндий, Орхон голын Дээд хөндий, Онгийн голын эх, Хүйсийн найман нуур орчмын бүс, Гурван Булган уул, Цэцэрлэг хот орчим, Цэнхэр, Шивэрт, Цагаан сүмийн рашаан орчим, Хорго-Тэрхийн цагаан нуур орчим, Чулуут голын сав дагуух бүс, Хануй голын сав дагуух бүс, Нууруудын хөндий Их богд орчмын бүс, Шатар чулуу, Шаргалжуутын рашаан орчмын бүс/ зэрэг бүсийг тодорхойлоод байна. Бүсийн зөвлөлийн хуралдааныг бүс бүрд зохион байгуулах Засгийн газрын шийдвэрийн хүрээнд "Хангайн бүсийн зөвлөл" анхдугаар хуралдаан 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Архангай аймагт зохион байгуулагдан. МУ-ын ЗГ-аас Хангайн бүсийг төрөлжсөн аялал жуулчлалын бүс болгох тухай 2025.04.14 ний 182 дугаар тогтоол гарсан. Хангайн бүсийн аялал жуулчлалын хөгжлийн орон зайг хөгжүүлэхэд дараах ажлуудыг ЗГ-ын тогтоолоор төлөвлөгөө гарган хийж байна. - Орхоны хөндийд "Төв Азийн түүх соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолборыг байгуулах ТЭЗҮ, ажил хийгдэж гүйцэтгэл 50 хувьтай | II улирал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. Эхлэлийн тайлан, зураг ирүүлээд байна. Тус ажлын гүйцэтгэлийн эхлэлийн тайлантай 2025 оны 05 сарын 21-ний өдөр ажлын хэсэг танилцан гэрээт ажил болох "Төв Азийн түүх соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолборын ТЭЗҮ боловсруулах ажилд газрын байршлыг орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, түүх соёл, Архитектурын мэргэжлийн зөвлөхөөс дүгнэлт гаргуулах зэрэг ажлуудыг шийдвэрлэх шаардлагатай байгаа тул гэрээг 2025оны 08 дугаар сарын 31-н хүртэл сунгасан. | | |
| 2 | 2.8.16 | Археологийн нөөцөд тулгуурласан "Төв Азийн түүх, соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолборын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах **АХ 2050-1.2.7, 1.2.8, 4.2.47, 8.2.2, ЗГҮАХХАХТ -1.3.1.3, 3.3.5.2, 3.3.5.9, ССАЖЗЯ- СТ – 5.5** | БХҮХ 900,0 | ТЭЗҮ-1 | Зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагаа зарлаж, гэрээ байгуулсан. | ТЭЗҮ боловсруулсан байна. | ССАЖЗЯ, БХҮХ, Ланд Овнер" ХХК-тай "Төв Азийн түүх, соёлын голомт" "Дөрвөн улирлын аялал жуулчлалын цогцолбор байгуулах" аялал жуулчлалын цогцолборын ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Гэрээт ажил "Төв Азийн түүх, соёлын голомт" ТЭЗҮ, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын захиргаа"-аас боловсруулж буй Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тусгай хэрэгцээнд авсан газраас гадагш талбайд, яам болон орон нутагтай зөвшилцөн Архангай аймгийн Өгий нуур сумын Цагаан толгойн Ар гэдэг газар 100га-д төлөвлөгөө хийгдэх болсон. Орхоны гүүр Мянганы замаас 8.5 кмт газар сонгогдсон. Гүйцэтгэл 50 хувьтай ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэл 40 хувьтай захиалагч хяналт тавьж буй байгууллагуудад эхлэлийн тайлан хүргүүлэн хянагдаж байна. Гүйцэтгэлийн эхлэлийн тайлантай 2025 оны 05 сарын 21-ний өдөр ажлын хэсэг танилцан гэрээт ажил болох "Төв Азийн түүх соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолборын ТЭЗҮ боловсруулах ажилд газрын байршлыг орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, түүх соёл, Архитектурын мэргэжлийн зөвлөхөөс дүгнэлт гаргуулах зэрэг ажлуудыг шийдвэрлэх шаардлагатай байгаа тул гэрээг 2025оны 08 дугаар сарын 31-н хүртэл сунгахаар болсон. | II улирал | 80% |
| 3 | 2.6.1 | Алтайн нуруу, бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн адал явдалт, тусгай сонирхлын, хил орчмын болон хил | - | Төлөвлөгөө -1 | Адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэх | Төлөвлөгөө боловсруулсан байна. | - Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан соёлын нөөц, байгалийн аялал жуулчлалын нөөц, тусгай сонирхлын аялал жуулчлалын нөөц тэдгээрийг газар зүйн байршилтай уялдуулан орон зайн дүн шинжилгээ хийж, тээвэр дэд бүтэц, логисток, эдийн | II-III улирал | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дамнасан аяллыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах<br>**АХ 2050-1.2.8, 4.2.47, 8.2.1**<br>**ЗГҮАХХАХТ -1.3.2.1, 3.3.5.2, 3.3.5.9**<br>**ССАЖЗЯ- СТ – 5.3, 5.5** | | | судалгаа хийгдсэн. | | засгийн коридор бүс нутгийн эдийн засгийн интеграци, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот суурин газар зэргийг харгалзан 7 аялал жуулчлалын бүсчлэл, 66 аялал жуулчлалын орон зайг тодорхойлсон. Энэ хүрээнд аялал жуулчлалын орон зай бүсчлэлээр Хангайн нурууны Отгонтэнгэр хайрханаас баруун тийш Завхан голын сав дагуух бүс нутгийг хамарсан Алтай нуруу, их нууруудын хотгор, Алтайн цаад говийн экосистемд түшиглэсэн адал явдалт, ангийн, угсаатан зүй, хил орчмын болон хил дамнасан аяллын чиглэлийг хөгжүүлэх олон угсаатны аялал жуулчлалын кластер бүсчлэл болон Отгонтэнгэр хайрхан орчмын шашин, соёлын аяллын бүсийн орон зайг тодорхойлсон. Тус орон зайг тодорхойлсноор аялал жуулчлалын тусгай бүс тогтоох урьдач нөхцөл бүрдэх юм. - Улсын аялал жуулчлалын бүс тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Тус шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон орон зайг мэргэжлийн судлаач, эрдэмтдээр нарийвчлан үнэлэх ажлыг гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн. | | |
| 4 | 2.6.1 | Их нуурууд, Отгонтэнгэр хайрханд тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүс тогтоох<br>**АХ 2050-1.2.8, 4.2.47, 8.2.1**<br>**ЗГҮАХХАХТ -1.3.2.1, 3.3.5.2, 3.3.5.9**<br>**ССАЖЗЯ- СТ – 5.3, 5.5** | - | Бүс -1 | Аялал жуулчлалын 15 орон зайг тодорхойлсон. | Аялал жуулчлалын тусгай бүсийг байгуулах судалгаа хийсэн байна. | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан соёлын нөөц, байгалийн аялал жуулчлалын нөөц, тусгай сонирхлын аялал жуулчлалын нөөц тэдгээрийг газар зүйн байршилтай уялдуулан орон зайн дүн шинжилгээ хийж, тээвэр дэд бүтэц, логисток, эдийн засгийн коридор бүс нутгийн эдийн засгийн интеграци, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот суурин газар зэргийг харгалзан 7 аялал жуулчлалын бүсчлэл, 66 аялал жуулчлалын орон зайг тодорхойлоод байна. Алтай Таван богд байгалийн цогцолбор газарт 4 улирлын аялал жуулчлалын цогцолбор байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд хүргүүлсэн.<br>Улсын аялал жуулчлалын бүс тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Тус шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон орон зайг мэргэжлийн судлаач, эрдэмтдээр нарийвчлан үнэлэх ажлыг гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн. | I-IV улирал | 70% |
| 5 | 2.6.3 | Хойд бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах | - | Төлөвлөгөө -1 | Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах, аюулгүй | Төлөвлөгөө боловсруулсан байна. | “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг хангах хүрээнд бүсүүдийн нөөц, даац, онцлогт тулгуурлан орон нутгийн эдийн засгийг нэмэгдүүлэхүйц төлөвлөлт хийж, аялал жуулчлалын хөгжлийн орон зайн үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлалыг хийх, бүсийн зураг” хийх ажлыг МУИС-ийн | II улирал | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **АХ 2050-1.2.8, 4.2.47, 8.2.2 ЗГҮАХХАХТ -1.3.3.1, 3.3.5.2, 3.3.5.9 ССАЖЗЯ- СТ – 5.3, 5.5** | | | байдлыг хангах журам батлагдсан. | | харьяа Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэнтэй хамтран гүйцэтгэж байна. Хойд бүсэд аялал жуулчлалын 9 орон зайг хөгжүүлэхээр ажиллаж байна. Дархадын хотгор – Улаантайгын нуруу орчмын бүс Дэлгэр мөрөн – Их-Уул орчмын бүс Жаргалант-Галтын халуун рашаан орчмын бүс Даян дээрхийн хийд, Үүрийн голын сав дагуух бүс Зэд, Хантай – Бүтээлийн нуруу орчмын бүс Уран тогоо – Шарга нуур орчмын бүс Орхон гол – Хулжийн рашаан орчмын бүс Баян-Өндөр сум орчмын бүс Бүсийн байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан “Хойд бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө”-ний төслийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор хамтран боловсруулахаар ажиллаж байна. Хатгал – Ханх чиглэлийн хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулснаар Ханх – Мондын боомтыг түшиглэсэн хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлал, Хөвсгөл нуурыг Байгаль нууртай холбосон бүтэн цагираг хэлбэрийн аяллын маршрутыг Ханх боомтоос Алтанбулаг, Сүхбаатар боомттой холбох боломж бүрдэнэ. “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028)” болон Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгээр Хатгал – Ханх чиглэлийн 110 км хатуу хучилттай авто замын ажил эхэлсэн.Аялал жуулчлалын 7 бүсчлэлд хуваан, 66 орон зайг тодорхойлж тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй тодорхойлон хийсэн.Бүсчилсэн хөгжлийн үндэсний зөвлөгөөн дээр аялал жуулчлалын бүсийн орон зайг танилцуулан хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр танилцуулга хийгдэж байна. | | |
| 6 | 2.6.1 | Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүс тогтоох **АХ 2050-1.2.8, 4.2.47, 8.2.2 ЗГҮАХХАХТ -1.3.3.1, 3.3.5.2, 3.3.5.9 ССАЖЗЯ- СТ – 5.3, 5.5** | - | Бүс -1 | Аялал жуулчлалын 8 орон зайг тодорхойлсон. | Аялал жуулчлалын тусгай бүсийг байгуулах судалгаа хийсэн байна. | Хөвсгөл аймагт 66 орон зайнаас Хөвсгөл орчмын бүс Дархадын хотгор – Улаантайгын нуруу орчмын бүс Дэлгэр мөрөн – Их-Уул орчмын бүс Жаргалант-Галтын халуун рашаан орчмын бүс Даян дээрхийн хийд, Үүрийн голын сав дагуух бүс зэрэг 5 орон зайг тогтоосон. Улсын аялал жуулчлалын бүс тогтоох 60 шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Тус шалгуур үзүүлэлтээр гаргасан суурь мэдээллүүд буюу 7 бүсийн | I-IV улирал | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгаль, түүх, соёлын нөөц, дурсгал, хөшөө зэргийг тодорхойлсон нь улсын аялал жуулчлалын бүсүүдийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах урьдач, суурь болох юм. Аялал жуулчлалын 7 бүсчлэлд хуваан, 66 орон зайг тодорхойлсннор орон зайг мэргэжлийн судлаач, эрдэмтдээр нарийвчлан үнэлэх ажлыг гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн. | | |
| 7 | 1.2.9 2.6.1 | Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх хүрээнд Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтан овоо, түүхэн аялал жуулчлалын газар нутгийг улсын аялал жуулчлалын бүс тогтоох **АХ 2050-1.2.8, 4.2.47, 8.2.4 8.2.5, 8.2.6 ЗГҮАХХАХТ -1.3.6.1, 3.3.5.2, 3.3.5.9 ССАЖЗЯ- СТ – 5.3, 5.5** | - | Бүсийн тоо | Аялал жуулчлалын 11 орон зайг тодорхойлсон. | Улсын аялал жуулчлалын бүс тогтоож, хил заагийг батлуулсан байна. | Зүүн бүсийн аялал жуулчлалын нөөц, даац, онцлогт тулгуурлан орон нутгийн эдийн засгийг нэмэгдүүлэхүйц төлөвлөлт хийх, аялал жуулчлалын хөгжлийн орон зайг тодорхойлох чиг үүрэг бүхий "Зүүн бүсийн аялал жуулчлалын"-ийн үүрэг бүхий ажлын хэсгийг 2025.03.21 ний 53 дугаар захирамж гарсан. Захирамжийн дагуу 2025 оны 05дугаар сарын 02-ний өдрийн А/172 дугаар Сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Хэнтий аймгийн бүс нутагт хэрэгжиж буй томоохон дэд бүтцийн төслүүд, Дорнод аймгийн хил орчмын аялал жуулчлал, Буйр нуурын усан зогсоол бүхий аялал жуулчлалын ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэлтэй тухайн газар дээр нь ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд ажилласан. Дээрх ажлын дагуу дэд бүтцийн ажлын гүйцэтгэгч байгууллагуудад хугацаатай чиглэл өгөн ажиллаж байна. Зүүн бүсийн 3 аймгийн аялал жуулчлалын зөвлөгөөн 2025 оны 05 дугаар сарын 17-18-ний өдрүүдэд Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан. Мөн Хэнтий аймагт Хөтөч, жолооч нарын сургалтыг аялал жуулчлалын холбоотой хамтран зохион байгуулсан. МУИС-ын "Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэн" Зүүн бүсийн аялал жуулчлалын үзэл баримтлалын хэрэгжилтийг хангах хүрээнд бүсүүдийн нөөц, даац, онцлогт тулгуурлан орон нутгийн эдийн засгийг нэмэгдүүлэхүйц төлөвлөлт хийж, аялал жуулчлалын хөгжлийн орон зайн үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлалыг хийн, бүсийн зураг төлөвлөлт хийж байна. | I-IV улирал | 80% |
| Зорилт 2. Дөрвөн улирлын аялал жуулчлал /ЗГҮАХХАХТ-ний 3.3.5/ | | | | | | | | |
| Зорилт 2.1 "Go Mongolia" арга хэмжээг үргэлжлүүлж, гадаад жуулчдын тоог жилд 2 саяд хүргэнэ. /ЗГҮАХХАХТ-ний 3.3.5.1/ | | | | | | | | |
| 8 | 2.1.10 | Аялал жуулчлалын цахим платформыг бий болгох төслийн ажлын даалгаврыг боловсруулах | ДБ-ны хөнгөлөл-тэй зээл | Боловсруулсан ажлын даалгавар | Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжих | Ажлын даалгавар боловсруулж, төслийн нэгжид | ЦХИХХЯ-ны дэргэдэх төслийн нэгжтэй хоёр удаагийн уулзалт хийж, Аялал жуулчлалын салбарын нэгдсэн платформын ажлын даалгаврыг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын даалгаврын эхний төслийг 2025 оны 4 сард төслийн нэгжид хүргүүлсэн. ССАЖЗ- | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **АХ 2050-4.2.44 ЗГҮАХХАХТ -3.3.5.1 ССАЖЗЯ- СТ – 1.3** | 1,5 сая ам.доллар | | төсөлд хамрагдсан. | хүргүүлсэн байна. | ын Сайд, Дэлхийн банкны Суурин төлөөлөгч Таехюн Ли, Төслийн багийн удирдагч, Цахимын ахлах мэргэжилтэн Сиоу Чев Куек, Дэлхийн банк Цахимын мэргэжилтэн Д.Амарбаясгалан, мөн ЦХИХХЯ-ны Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын дарга, Төслийн захирал Б.Бат-Өлзий, ЦХИХХЯ-ны Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Төслийн ахлах мэргэжилтэн Э.Болормаа, Ухаалаг засаг-2 Төслийн зохицуулагч Б.Энхдэлгээн нартай 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр уулзалт хийсэн. Аялал жуулчлалын салбарын нэгдсэн платформ нь Монгол Улсыг гадаад улс орнуудад сурталчлах албан ёсны нэг цонхны сурталчилгаа, мэдээллийн портал байх бөгөөд гадаад, дотоодын жуулчид шаардлагатай мэдээлэл авах, аж ахуйн нэгжүүдтэй холбогдох, захиалга өгөх, аж ахуйн нэгжүүд сурталчилгаа мэдээллээ түгээх, хэрэглэгчидтэй болон өөр хоорондоо холбогдох, борлуулалтаа нэмэгдүүлэх зэрэг асуудлуудыг шийдэхэд чиглэгдсэн байна. Уг төлсийг хэрэгжүүлэхээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, 3 удаагийн уулзалт зохион байгуулж ажлын даалгаврыг нэмж сайжруулав. | | |
| 9 | 2.6.8 | Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт татах, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хөнгөлөлттэй зээл олгох<br><br>**АХ 2050-4.2.43 ЗГҮАХХАХТ -3.3.5.1 ССАЖЗЯ- СТ – 5.5** | АЖХЗ 20.041,0 | Зээл авсан ААНБ-ын тоо | 54 ААНБ-д хөнгөлөлттэй зээл олгосон. | Зээлийн нөхцөлийг тодорхойлж, ААНБ-д хөнгөлөлттэй зээл олгосон байна. | ССАЖЗЯ-ны 2025 оны санхүүгийн жилд Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт татах, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор 20.0 тэрбум төгрөгийг төсөвлөн батлуулсан. Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжин нийт 2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкнуудын эх үүсвэрт тулгуурлан 6.0 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг бэлтгэн Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын ...-ны өдрийн хуралдааны .... дугаар тэмдэглэл гарсан.<br>Уг ажлын хүрээнд хөнгөлөлттэй зээл олгох тухай Засгийн газрын тогтоолтой холбогдуулан Хаан банк, Хас банк, Төрийн банк, Капитрон банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг арилжааны банкуудын төлөөлөлтэй 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох тухай танилцуулга, мэдээлэл хүргэж, "Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээл"-ийн | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | урьдач нөхцөлийн талаар арилжааны банкуудтай хэлэлцүүлэв.<br>Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан 6.0 хувийн хүүтэй, 6 жил хүртэлх хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох "Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох тухай" Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоол батлагдсан.<br>"Аялал жуулчлалын сургалтын төв"-ийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нээлтийн арга хэмжээний үеэр "Үнэт санхүүгийн нэгдэл"-ийн төлөөлөгч аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийн талаар төр, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулсан.<br>Хаан банк, Хас банк, Төрийн банк, Капитрон банк зэрэг арилжааны банкуудаас санхүүжилтийн гэрээний төсөлд санал авч, 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хэлэлцүүлсэн. | | |
| 10 | 1.2.2 1 | Хууль, эрх зүйн орчныг таниулан сурталчлах арга хэмжээг зохион байгуулах<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ – 5.5** | - | Арга хэмжээний тоо | 4 аймгийн аялал жуулчлалын форумд танилцуулга хийсэн. | Аялал жуулчлалын арга хэмжээ бүрт хууль эрх зүйн нөхцөлийг танилцуулсан байна. | 1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласны хүрээнд "Tourism week-2025" арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 10-аас 14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Улаанбаатар зочид буудалд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулав. Аялал жуулчлалын үндэсний чуулганаар "Аялал жуулчлал ба бүсчилсэн хөгжил" сэдэвт хэлэлцүүлэгийг салбарын бодлого, аялал жуулчлалын бүсчлэлийн талаар холбогдох төрийн байгууллага, салбарын төлөөлөл, эрдэмтэн судлаачидтай хэлэлцүүллээ. Мөн төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлогын талаар танилцуулга хийж, Хууль, эрх зүй, стандарт, дэд бүтэцийг танилцуулсан.<br>2. Хөвсгөл, Өвөрхангай, Дундговь, Ховд аймгуудын аялал жуулчлалын зөвлөгөөнд Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор аялал жуулчлалын салбарт | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйл ажиллагаа эрхлэгчдэд арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан 6.0 хувийн хүүтэй, 6 жил хүртэлх хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох "Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох тухай" Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоол батлагдсан тухай хууль эрхзүйн нөхцлийг танилцуулсан. | | |
| Зорилт 2.2. Аялал жуулчлалын томоохон парк, цогцолборыг бүсчилсэн хөгжлийн хүрээнд байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-ний 3.3.5.2/ | | | | | | | | | |
| 11 | - | Байгалийн нөөцийн зохистой ашиглалтыг нэмэгдүүлж, адал явдалт аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх<br><br>**АХ 2050-4.2.47, 6.1.8, 8.2.2**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.2**<br>**ССАЖЗЯ- СТ – 5.3** | - | Байгалийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, тоогоор | НИТАЖ, Адал явдалт аялал жуулчлалын судалгаа хийгдсэн. | Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ бүтээгдэхүүн бий болгосон байна. | 1. НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран гаргасан "Гэр ба байгаль" концепцыг "Tourism week" арга хэмжээнд орон нутагт НИТАЖ-ыг хөгжүүлэх чиглэлээр танилцуулга хийсэн. Дээрх ажлын хүрээнд Архангай аймагт "Малчин кемп" төсөл, Булган аймагт "Хантай" нутгийн иргэдийн аялал жуулчлалын хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Архангай аймаг малчин Кемп нь Монголын нүүдэлчин соёлтой танилцах, малчин айлд зочилж, тэдний амьдралын хэв маягийг мэдрэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон. Архангай аймгийн үзэсгэлэнт байгальд байрлах 30 гаруй байршилд 60 малчин айл жуулчдыг хүлээн авч, малчин амьдралын өдөр тутмын хэв маяг, уламжлал, зан үйлтэй танилцах боломжийг олгох. 1 байршилд 2 айл хамт амьдардаг бөгөөд 4 ортой 2 илүү гэр буюу нийт 8 ортой 2 гэрт жуулчин хүлээн авдаг. Малчин айлд зочлохдоо дараах үйл ажиллагаануудыг хийж үздэг. НИТАЖ-ийн чиглэлээр Архангай, Баян-Өлгий, Булган, Хэнтий, Дорнод, Говь-Алтай, Баянхонгор, Төв зэрэг аймгууд сургалт зөвлөгөөн хийн ажиллаж байна. ТАЖХТ хүрээнд төсөл хэрэгжүүлж буй газруудад НИТАЖ-ын сургалтууд хийгдсэн. -TNC Олон улсын төсөл "Өнө мөнхийн Монгол" хөтөлбөрийн хүрээнд НИТАЖ-ын сургалтууд баруун аймгуудад хийгдэж байна. 2. Адал явдалт аялалын холбоотой хамтран монголын хөтөч, аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн мэргэжлийн түвшинг дээшлүүлж, олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх, Монгол Улсыг Адал явдалт аяллын шинэ чиглэл болгон таниулах маркетингийн боломжийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдол бүхий адал явдалт аялал жуулчлалын хөтчийн сургалт, хөтөлбөрийг 2025 оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн. | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | 1.2.8 | Аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, улирлын хамаарлыг бууруулах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Дөрвөн улирлын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө" гаргаж хэрэгжүүлэх **АХ 2050-4.2.43, 4.2.47 ЗГҮАХХАХТ -3.3.5.2 ССАЖЗЯ- СТ – 5.1** | - | Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | Засгийн газрын 2024 оны 191 дүгээр тогтоол батлагдсан. | "Дөрвөн улирлын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө" боловсруулж, хэрэгжүүлтийг 25%-д хүргэсэн байна. | 1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны 2025 оны анхдугаар хуралдаан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн БНХАУ-ын Харбин хотноо хийсэн албан айлчлалын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр хорооны гишүүдийн төлөөлөл болон салбарын төлөөллүүд, Улсын их хурлын дөрвөн гишүүдийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулагдав. БНХАУ-ын Харбин хотод болсон 40 дэх удаагийн өвлийн аялал жуулчлалын "Харбин олон улсын цас мөсний баяр"-ын арга хэмжээнд ССАЖЗ-ын сайд болон сайдын зөвлөх С.Баясгалан нар оролцож, туршлага судлав.<br>2. Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан 6.0 хувийн хүүтэй, 6 жил хүртэлх хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох "Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох тухай" Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоол батлагдсан.<br>3. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2025 оны хуралдаанаар "Монгол улсад 2025 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн цаглавар"-ыг 2-р тэмдэглэлээр баталгаажуулж шийдвэрлэсний дагуу "Мазаалай – 2025", Мөсөн сийлбэрийн олон улсын уралдаан, Хөвсгөл аймгийн "Хөх сувд-2025" эвентүүдэд дэмжлэг үзүүлсэн. 4. Засгийн 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу Хүйтний улиралд ажлын цагийн зохицуулалт хийх, "Жаргалтай өвөл" арга хэмжээг өвлийн аялал жуулчлал, гэр бүлд ээлтэй байдлаар жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрөөс дараа жилийн 01 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд зохион байгуулах хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажлын хэсэг ажиллан төлөвлөгөөний төсөлд санал өгөв. | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | 2.6.17 | Үндэсний уламжлал, соёлын өвийн онцлогт тулгуурласан гадаадын жуулчдын эрэлт, сонирхолд нийцсэн гар урлалын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх **АХ2050-4.2.43, ЗГҮАХХАХТ-ний 3.3.5.2, АЖТХ-21.1.1, ССАЖЗЯ-СТ-5.3** | 87.0 | Дэмжлэг үзүүлсэн бүтээгдэхүүний тоо | - | Дэмжлэгийг 2-оос багагүй бүтээгдэхүүнд үзүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бүс орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх хүрээнд “Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан”-ыг Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооноос 7 бүсэд хуваарийн дагуу зохион байгуулж байна.<br>Уг ажлын хүрээнд тус яамнаас Хангайн бүсийн салбарын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Өвөрхангай аймагт, Хойд бүсийн салбарын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Орхон аймагт, Говийн бүсийн "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Дундговь аймагт, тус тус зохион байгуулсан. Дээрх бүсийн зөвлөгөөний хүрээнд тухайн бүсийн аймгийн ССАЖЗ-ын газар, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөл хоршоодын онцлог бүтээгдэхүүнийг танилцуулсан үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.<br>“Аялал жуулчлалын сургалтын төв”-ийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нээлтийн арга хэмжээний үеэр Архангай, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Дорнод, Өвөрхангай, Баянхонгор, Төв, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Булган, Дархан-Уул, Ховд, Орхон аймгуудын ССАЖЗ-ын газраас оролцож, өөрсдийн уламжлал идээ, соёлын онцлог бүхий бүтээгдэхүүн зэргийг нээлтийн арга хэмжээнд оролцогчид, олон улсын төлөөлөгчдөд сурталчлан танилцуулсан.<br>Монгол Улсыг гадаадад сурталчлах, жуулчдыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан “Go Mongolia” арга хэмжээнд үндэсний, дотоодын үйлдвэрлэгчийн ноос ноолууран бүтээгдэхүүн, материалд Сайдын 2025 оны “Зардал батлах тухай” тушаалаар дэмжлэг үзүүлэн ажилласан. | I-IV улирал | 100% |
| Зорилт 2.3. Аялал жуулчлалын салбарын стандарт, үйлчилгээний чанар, визний шаардлагыг хөнгөвчилнө. /ЗГҮАХХАХТ-ний 3.3.5.4/ | | | | | | | | |
| 14 | 1.2.18 | Аялал жуулчлалын салбарын стандартуудыг шинэчлэн боловсруулж, батлуулах<br><br>**АХ 2050-4.2.45 ЗГҮАХХАХТ -3.3.5.4** | - | Шинээр болон шинэчлэн батлуулсан стандартын тоо | Аялал жуулчлалын үйлчилгээний 5 стандарт шинчлэгдэн боловсруулагдсан. | Байршуулах хэрэгслийн 5 стандартыг батлуулсан байна. | Аялал жуулчлалын салбарын байршуулах хэрэгслийн 5 стандартын төслийг Монголын зочид буудлын холбоотой хамтран хэлэлцүүлж, дараах стандартуудыг шинэчлэн боловсруулсан.<br>- MNS 4588:2008 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлагын стандарт; | I-IV улирал | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **ССАЖЗЯ- СТ – 5.3** | | | | - MNS 5927:2008 Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандарт<br>- MNS 6043:2019 Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлагын стандарт<br>- MNS 5738:2007 Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлагын стандарт<br>- Гэр буудлыг стандарт;<br>Стандарт, хэмжил зүйн газар болон Аялал жуулчлалын мэргэжлийн холбооноос стандартын төсөлд эцсийн санал авах ажлыг зохион байгуулж байна. | | |
| 15 | 1.2.18 | Стандартын шаардлага, байгаль орчинд ээлтэй байршуулах хэрэгслийг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх<br><br>**АХ 2050-4.2.45**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.4**<br>**ССАЖЗЯ- СТ – 5.3** | - | Стандартын шаардлага хангасан байршуулах хэрэгсэл, өссөн тоогоор | Дээд зэрэглэлийн стандартын шаардлага хангасан зочид буудлын тоо 83 байгаа. | Стандартын шаардлага хангасан үйлчилгээний байгууллагуудын тоо нэмэгдсэн байна. | Стандартын шаардлага, байгаль орчинд ээлтэй байршуулах хэрэгслийн нөхцөл байдлыг тодорхойлох суурь судалгааг хийхээр төлөвлөсөн.<br>“Монгол улсын жуулчны бааз түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгаа”-ны ажлыг даалгаврыг боловсруулсан.<br>“Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын оролцогч талуудын 17 дугаар Бага хурал (COP17)”-ыг 2026 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс 08 дугаар сарын 28-ны өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулахтай холбогдуулан Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 28 дугаар тогтоол, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын баталсан Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг зохион байгуулах дэд хорооны бүрэлдэхүүн, чиг үүргийн 9-д тус тус заасны дагуу Соёл, аялал жуулчлалын хөтөлбөр, зочид буудал хариуцсан дэд хорооны анхдугаар хурлыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан бөгөөд COP17 Бага хурлын үеэр соёл, урлагийн тоглолт, үзэсгэлэн арга хэмжээ зохион байгуулах, аяллын хөтөлбөр, маршрут гаргах, зочид буудал байршуулах дэд бүтцийн асуудлыг хариуцан ажиллах чиг үүргийг хүлээн холбогдох талууд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Монголын зочид буудлуудын холбоо зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байна. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд “Go Mongolia” нэгдсэн брэндингийн дор Монгол Улсаа сурталчилж, зочид төлөөлөгчдийг тав тухтай байх, үндэсний өнгө төрх бүхий олон үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж ажиллах 2025-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлыг эрчимжүүлж байна. | I-IV улирал | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | - | Зочлох, байршуулах үйлчилгээний байгууллагын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал боловсруулах **АХ 2050-4.2.45 ЗГҮАХХАХТ -3.3.5.4 ССАЖЗЯ- СТ – 5.3** | - | Аргачлал-1 | Аялал жуулчлалын салбарын статистик тооцох аргачлал батлагдсан. | Байршуулах үйлчилгээний байгууллагын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал боловсруулж, батлуулсан байна. | Алсын хараа-2050, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ССАЖЗЯ-ны стратеги төлөвлөгөөний дагуу Үндэсний статистикийн хороотой хамтран зочлох, байршуулах үйлчилгээний байгууллагын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалын төсөл боловсруулсан. Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн болон даргын хурлаар оруулж, зөвлөмж өгч, Үндэсний статистикийн хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/31 дугаар "Аргачлал, маягт, нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтаар Байр сууцаар хангах, нийтийн хоолны салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, 2 дугаар хавсралтаар Байр сууцаар хангах, нийтийн хоолны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч (иргэн)-ийн орлогын сарын мэдээний маягт (А-БСНХ-1) нөхөх зааврыг тус тус шинэчлэн батлуулав. | I-II улирал | 100% |
| Зорилт 2.4. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдааны сувгуудаар дэмжинэ. /ЗГҮАХХАХТ-ний 3.3.5.6/ | | | | | | | | | |
| 17 | - | Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, орлогыг нэмэгдүүлэх<br><br>**АХ 2050-8.3.11 ЗГҮАХХАХТ -3.3.5.6 ССАЖЗЯ- СТ – 5.3** | - | Нутгийн иргэдэд түшиглэсэн олох орлогын өсөлт, хувиар | НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран гаргасан "Гэр ба байгаль" концепц батлагдсан. | Нутгийн иргэдийг аялал жуулчлалын салбараас орлого олох системийг бүрдүүлэх | НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран гаргасан "Гэр ба байгаль" концепцыг "Tourism week" арга хэмжээний орон нутагт НИТАЖ-ыг хөгжүүлэх чиглэлээр танилцуулга хийн чиглэл өгсөн. Дээрх ажлын хүрээнд Архангай аймагт "Малчин кемп" төсөл, Булган аймагт "Хантай" нутгийн иргэдийн аялал жуулчлалын хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Архангай аймаг малчин Кемп нь Монголын нүүдэлчин соёлтой танилцах, малчин айлд зочилж, тэдний амьдралын хэв маягийг мэдрэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Архангай аймгийн үзэсгэлэнт байгальд байрлах 30 гаруй байршилд 60 малчин айл жуулчдыг хүлээн авч, малчин амьдралын өдөр тутмын хэв маяг, уламжлал, зан үйлтэй танилцах боломжийг олгох, 1 байршилд 2 айл хамт амьдардаг бөгөөд 4 ортой 2 илүү гэр буюу нийт 8 ортой 2 гэрт жуулчин хүлээн авдаг. Малчин айлд зочлохдоо дараах үйл ажиллагаануудыг явуулна. Малын бэлчээрт гарах – Морь, тэмээ, сарлаг унаж үзэх, малаа хариулах, Сүү, цагаан идээ боловсруулах – Айраг бүлэх, ааруул хийх, сүү саах, Монгол хоол хийх – Бууз, хуушуур, цуйван зэрэг хоол хийх арга сурах, Гар урлал, монгол тоглоом – Арьс, эсгий урлал хийх, шагайгаар , Малчин айлын амьдралд | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцох, Гэр барих, тулээ хагалах, ус, Оддын дор хоноглох – Гэрт хонох, галын наадам хийх, түүх домог сонсох НИТАЖ-ийн чиглэлээр Архангай, Баян-Өлгий, Булган, Хэнтий, Дорнод, Говь-Алтай, Баянхонгор, Төв зэрэг аймгууд сургалт зөвлөгөөн хийн ажиллаж байна. ТАЖХТ хүрээнд төсөл хэрэгжүүлж буй газруудад НИТАЖ-ын сургалтууд зохион байгуулсан. TNC ОУ-ын төслийн "Өнө мөнхийн Монгол" хөтөлбөрийн хүрээнд НИТАЖ-ын сургалтууд баруун бүсийн аймгуудад мөн зохион байгуулсан. Тус байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар тохиролцоод байна. Аялал жуулчлалын салбарын дэмжих хөнгөлөлттэй зээлийн хүрээнд эргэлтийн хөрөнгийн зээлээр бичил зээлийн бүтээгдэхүүнийг тусгаж, гар урлал, үйлдвэрлэл зэрэг орон нутгийн бичил бизнес эрхлэгчдийг хамруулах болсон. | | |
| Зорилт 2.5. Аялал жуулчлалын гол зам дагуу амрах өртөө, түр отоглох цэг, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 3.3.5.7/ | | | | | | | | | |
| 18 | - | Аялал жуулчлалын гол замын дагуу амрах өртөө, түр буудлах үйлчилгээний цогцолборыг байгуулах ажлыг идэвхжүүлэх<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.7**<br>**ССАЖЗЯ- СТ** | - | Ажлын гүйцэтгэл, хувь | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулагдаж байгаа. | Авто зам дагуух үйлчилгээний цогцолборуудын байршлыг тодорхойлж, гэрээ байгуулан, хөнгөлөлттэй зээлэнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 74, 189 дүгээр тогтоолоор Аялал жуулчлалын гол чиглэл, Олон улс, улсын чанартай авто зам дагуу үйлчилгээний цогцолборыг нийт 58 байршилд хийхээр төлөвлөсөн. Уг ажлын төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах, үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ЗТЯ баталсан. Дээрх ажлын хүрээнд "Зам дагуух үйлчилгээний байгууллагын холбоо"-той хамтран Хангайн бүс, Хойд бүсэд шинээр үйл ажиллагаа явуулах байгууллагын газар олголтын талаар Хангайн бүсийн зөвлөгөөнөөр орон нутгийн удирдлага, холбогдох албан тушаалтнуудтай 2025 оны 04, 05 дугаар саруудад уулзалт хийн Хангай, Хойд, Говийн бүсийн чуулганд оруулан танилцуулж Засгийн газрын тогтоолд зарим газруудын өөрчлөлт хийн оруулсан. Одоогоор нийт 6 байршилд баригдсан, 5 байршилд баригдаж, 11 газарт гэрээ байгуулах хүсэлт ажлын хэсэгт ирүүлээд байна. | I-IV улирал | 90% |
| 19 | - | Байгаль, түүх, соёлын үзэсгэлэнт газруудад ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгийн байршлыг тодорхойлох | - | Отоглох цэгийн тоо | 42 цэгт отоглох цэг байгуулагдсан байгаа. | Отоглох цэг байгуулах цэгийг тодорхойлж, төр, хувийн | Байгаль, түүх, соёлын өв бүхий жуулчдын зорин очих газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах газрын байршлыг аймаг орон нутгаас санал авч тодорхойлон 2024 онд 9 байршилд отоглох цэг байгуулсан. | I-II улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | АХ 2050-4.2.43<br>ЗГҮАХХАХТ -3.3.5.7<br>ССАЖЗЯ- СТ | | | | хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгох саналыг боловсруулж, танилцуулсан байна. | Үүнд: - Завхан аймгийн Тэлмэн сумын Тэлмэн нуурын эрэгт - Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум Балданбэрээвин хийд - Булган аймгийн Рашаант сум Элсэн тасархай - Говь-Алтай аймгийн Хөх морьт сумын Дөргөн нуур 2025 онд Говь-Алтай аймгийн Тайшир сум, завхан голын эргийг тохижуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын санал өгч орон нутгийн төрийн худалдан авах газраас 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр СЯ/20250103046 дугаар тендер зарласан. Одоогоор гүйцэтгэгч компанийг шалгаруулах ажил явагдаж байна. | | |
| Зорилт 2.6. Говийн бүсийн Марс гарагтай төсөөтэй онцлогийг шинжлэх ухаан, инновац шингэсэн технологиор баяжуулж, байгаль орчинд ээлтэй, дөрвөн улирлын тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | | | | | | | | | |
| 20 | - | Говийн бүсийн Марс-V төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах<br><br>АХ 2050-8.2.3<br>ЗГҮАХХАХТ -3.3.5.10<br>ССАЖЗЯ- СТ-5.3 | - | Гүйцэтгэлийн хувь | Марс-V төслийн багтай хамтран ажилласан. | Говийн бүсийн Марс-V төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажилласан байна. | Сансрын технологийн шинжлэх ухааны туршилт, судалгаа, хөгжүүлэлтээр дамжуулан дэлхийд Монгол Улсын үнэ цэнийг өсгөх боломжийг олгож буй “Марс Ви” төслийг хэрэгжүүлж байна. Монголын говь Марс тест орчинд Марс гарагт гүйцэтгэх даалгавар симулиацаар туршиж, бэлтгэл хийх төвлөрсөн дэд бүтцээс хамааралгүй аналоги төв байгуулсан байна.<br>1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Марс-Ви” төслийн асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсэг 2024 оны 12-р сарын 6 нд байгуулагдаж, 2025 оны 4-р сарын 25 нд анх дугаар хурлыг зохион байгуулсан.<br>2.Марс тест гадаргуу дээр явагч тээврийн хэрэгслийг бүтээх ТЭЗҮ боловсруулах ажил явагдаж байна.<br>3.“Марс-Ви” төслийн алсын зайн удирдлагын төвийн газрыг шийдэх талаар газрын судалгаа хийж байна. | I-IV улирал | 100% |
| Зорилт 2.7. Үндэсний болон олон улсын спортын арга хэмжээг зохион байгуулах, дэмжих замаар аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | | | | | | | | | |
| 21 | 2.6.1 3 | Монгол Улсыг сурталчлах “Go Mongolia” арга хэмжээг голлох зах зээлийн орнуудад зохион байгуулах<br><br>АХ 2050-4.2.43, 4.2.44<br>ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11<br>ССАЖЗЯ- СТ-5.4 | 1.000.0 | “Go Mongolia” арга хэмжээний тоо | “Go Mongolia” арга хэмжээг БНХАУ, Япон, Щвейцар, Их Британи зэрэг 7 улсад зохион байгуулсан. | “Go Mongolia” арга хэмжээг БНСУ, ХБНГУ, Япон, АНУ, Тайвань,БНЭУ, Хонгконг, БНХАУ зэрэг голлох зах зээлийн орнуудад | Монгол Улсыг сурталчлах “Go Mongolia” арга хэмжээг голлох зах зээлийн орнуудад зохион байгуулах хүрээнд ОХУ-ын Москва хотноо 2025 оны 06-р сарын 10-аас 15-ны өдөр зохион байгуулагдах “Let's Travel” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож эхэлсэн.<br>Энэхүү үзэсгэлэнд оролцсоноор Оросын жуулчдад Монгол Улсыг шинэ, найдвартай аяллын чиглэл болгон сурталчлах, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, тогтвортой аяллыг төлөвлөх боломж бүрдэнэ. | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулж, сурталчилсан байна. | Геополитикийн өөрчлөлт, олон улсын аяллын чиглэл хязгаарлагдсаны улмаас ОХУ-ын иргэдийн дунд шинэ, аюулгүй, ойрын чиглэлүүдэд хандсан аяллын эрэлт эрс нэмэгдэж байна. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Монголын аялал жуулчлалын холбоо бүртгэл, зохион байгуулалтыг хийж гүйцэтгэсэн. Тус үзэсгэлэнд ХишигДаймонд, Пакс Номадик, ХаппиТрип зэрэг тур операторуудын төлөөлөл, Гоёл кашмераас ноос ноолууран бүтээгдэхүүний танилцуулж, үндэсний язгуур урлагийн үзүүлбэрийг толилууллаа.<br>Мөн ССАЖЗЯ-ны НТХ-ийн шинжээч, Сэлэнгэ аймгийн СУАЖЗГ-ын дарга нар туршлага судлахаар оролцсон. | | |
| 22 | 2.6.15 | Аялал жуулчлалын салбарын бүтээлч контентыг бий болгож, цахим сувгаар сурталчлах<br><br>**АХ 2050-4.2.43, 4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.4** | 50.0 | Аялал жуулчлалын контентын тоо | - | Аялал жуулчлалын 5 контент бий болгож, цахим сувгаар сурталчилсан байна. | Монгол Улсын нэг сая жуулчин хүлээн авах, аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох зорилтын хүрээнд Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, Монгол Улсыг "Go Mongolia" уриан дор нэгдсэн зохион байгуулаттайгаар соёл урлаг, аялал жуулчлалыг сурталчлан танилцуулах үүднээс мэдээ нийтлэл бэлтгэж "Түмэн тэмээний баяр" арга хэмжээг шууд дамжуулалт хийх, "Хөх сувд-2025" арга хэмжээний 20-40 минутын видео контент хийх ажлыг гүйцэтгэж дууссан тул "Визард Анимейшн" ХХК-тай 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр гэрээлэн ажил гүйцэтгэсэн гэрээг дүгнэн санхүүжилтийг олгуулав. "Түмэн тэмээний баяр" арга хэмжээг шууд дамжуулалт хийсэн ба Видео контент 20-40 минут; Go Mongolia уриан дор Монгол улсыг нэгдсэн өнгө төрхөөр сурталчилах рийл контент, Монгол Улсын соёл урлаг, аялал жуулчлалыг сурталчлан танилцуулах үүднээс мэдээ нийтлэлийг цацаж "Хөх сувд-2025" арга хэмжээний 6-7 контенттой болов. | I-IV улирал | 100% |
| 23 | 2.6.20 | Өвлийн аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын наадам, арга хэмжээг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх<br><br>**АХ 2050-4.2.43, 4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3, 5.4** | 1,370.0 | Наадмыг зохион байгуулсан байх | "Мазаалай" цас мөсний олон улсын наадмыг 2024 онд анх удаа зохион байгуулсан. | "Мазаалай" цас мөсний наадмыг зохион байгуулж, Олон улсын мөсөн сийлбэрийн уралдаан, "Хөх сувд-2025" мөсний баярыг зохион | Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласны хүрээнд "Tourism week-2025" арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 10-аас 14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Улаанбаатар зочид буудалд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулав. "Tourism week 2025" аялал жуулчлалын үндэсний чуулганы 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр "Аялал жуулчлал ба бүсчилсэн хөгжил" сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, салбарын бодлого, аялал жуулчлалын бүсчлэлийн талаар холбогдох төрийн байгууллага, | I улирал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна. | салбарын төлөөлөл, эрдэмтэн судлаачидтай хэлэлцүүллээ. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, Монгол Улсад аялах жуулчдын сэтгэл ханамж, ая тухтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Хөвсгөл аймагт зохион байгуулах "Хөх сувд" олон улсын арга хэмжээ 2025 оны 02 дугаар сарын 13-22-ны өдрүүдэд, Улаанбаатар хотын Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 2025 оны 02 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Мазаалай" олон улсын цас, мөсний наадам, "Нүүдэлчдийн өвөл" арга хэмжээг жил бүр олон улсын түвшинд зохион байгуулахаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газартай хамтран төлөвлөгөө гарган ажиллав. Олон улсын мөсөн сийлбэрийн 2 дахь удаагийн тэмцээн 2 дугаар сарын 23-аас 26-ны өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд амжилттай зохион байгуулав. Тэмцээнд АНУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНЧУ, БНПУ, Малайз, Мексик, Якут улсуудаас уран бүтээлч оролцож, дотоодын 4, гадаадын 10 багийн нийт 28 уран бүтээлчид сийлбэрээ урлаж, авьяас чадвараараа өрсөлдсөн юм. | | |
| 24 | 2.6.15 | "Go Mongolia" нэгдсэн брэндингийн дор Монгол Улсыг сурталчлах 4 улирлын аялал жуулчлалын контент бий болгох, олон улсын сувгаар түгээх<br>**АХ 2050-4.2.43, 4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.4** | 160.0 | Аялал жуулчлалын контентын тоо | - | 4 улирлын 20 контентын бүтээж, олон улсын сувгаар сурталчилсан байна. | Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг сурталчлахад хэрэгцээтэй мултимедиа контентийн сан бүрдүүлэхээр Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Соёлын өвийн үндэсний төв, Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо хамтран төлөвлөгөө боловсруулсан. Энэхүү нэгдсэн контентын санг бүрдүүлснээр улсын хэмжээний болон салбарын хувийн хэвшлийн байгууллагуудад маркетинг сурталчилгаандаа ашиглах бүрэн боломжтой болох юм. | I- IV улирал | 100% |
| 25 | 2.6.22 | Үндэсний хэмжээний аялал жуулчлалын арга хэмжээг дэмжин хамтран ажиллах<br><br>**АХ 2050-4.2.43, 4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3, 5.4** | 490.0 | Арга хэмжээний тоо | Эвентийн календарийг батлуулсан. | Олон улсын, үндэсний, орон нутгийн 10 арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна. | Монгол Улсад 2025 онд зохион байгуулагдах соёл, аялал жуулчлал, спорт, хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн арга хэмжээний нэгдсэн цаглабарыг нийслэл, 21 аймаг, төрийн байгууллагуудын саналыг үндэслэн боловсруулж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцуулж, батлуулав. Хуралдаанаар Аялал жуулчлалын тухай хуулийн 23.1.7 заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд, жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө дараа жилийн арга хэмжээний саналыг ирүүлэх чиглэл өгөв. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.5-т | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | туссан “Дөрвөн улирлын аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх зорилтын хэрэгжилтийг хангах үүднээс 11 эвентийг санхүүжүүлхээр 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдөр ССАЖЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/50 тоот тушаалыг батлуулав. ҮҮнд: 1. “Түмэн тэмээний баяр” арга хэмжээ-30,0 сая төг 2.Талын түмэн адуу фестиваль-20,0 сая төг 3.Айс Фестиваль-20,0 сая төг 4.Бүргэдийн баяр-20,0 сая төг 5.АРА Фестиваль-20,0 сая төг 6.Айраг фестиваль-10,0 сая төг 7.Монгол туургатны харвуул их наадам-10,0 сая төг 8.Цайны зам соёлын өвийн наадам-10,0 сая төг 9.Дарьганга фестиваль-10,0 сая төг 10.“One day of Mongolia” Аялал жуулчлалын гэрэл зургийн эвент-10,0 сая төг 11.Жангар тууль хайлах наадам-10,0 сая төгрөгөөр батлагдаад байна. | | |
| 26 | 2.6.7 | "Их түмэн санаачилга"-ын Аялал жуулчлалын хорооны XVI уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулах<br><br>**АХ 2050-4.2.43, 4.2.44, 4.2.48**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3, 5.4** | 100.0 | "Их түмэн санаачлага"-ын XVI уулзалт зохион байгуулсан эсэх | "Их түмэн санаачлага"-ын XV уулзалтад оролцсон. | "Их түмэн санаачлага"-ын XVI уулзалт зохион байгуулсан байна. | "Их түмэн санаачилга"-ын Аялал жуулчлалын хорооны XVI уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулах талаар анхны цахим хурлыг АЖБХЗГ, ГХОУМСХА-ын төлөөлөл 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр ОХУ-ын талтай хийсэн. Тус хурлаас уулзалтыг зохион байгуулах хугацааг Монгол, Орос, Хятад 3 улсын сайд нарын уулзалтын үеэр зохион байгуулах боломжтой талаар хэлэлцэв. Уулзалтад оролцох тухай саналыг ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг талуудад хүргүүлэхээр ажиллаж байна. | II-III улирал | 50% |
| 27 | 2.6.9 | НҮБ-ын ДАЖБ-ын Ази, Номхон Далайн бүсийн 20 гаруй улсын "Аялал жуулчлалын яамдын гүйцэтгэх удирдлагуудыг чадавхжуулах хөтөлбөр"-ийг Улаанбаатар хотноо зохион байгуулах<br><br>**АХ 2050-4.2.43, 4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3, 5.4** | 100.0 | Арга хэмжээ зохион байгуулсан эсэх | НҮБ-ын ДАЖБ-ын Ази, Номхон Далайн бүсийн "Аялал жуулчлалын яамдын гүйцэтгэх удирдлагуудыг чадавхжуулах хөтөлбөр"-т оролцсон. | "Аялал жуулчлалын яамдын гүйцэтгэх удирдлагуудыг чадавхжуулах хөтөлбөр"-ийг Улаанбаатар хотноо зохион байгуулсан байна. | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аялал жуулчлалын бодлого, стратегийн 19 дэх удаагийн Ази, Номхон далайн бүсийн удирдах албан тушаалтнуудыг чадавхжуулах хөтөлбөр "Аялал жуулчлал ба соёл" сэдвийн хүрээнд Монгол Улсад 05 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулав. Дэлхийн хэмжээнд 2024 оны байдлаар аялал жуулчлалын салбар 10.9 их наяд ам.доллар буюу ДНБ-ий 10%-ийг бүрдүүлж, 340 сая орчим ажлын байрыг дэмжиж байна. Харин Ази, Номхон далайн бүсийн аялал жуулчлалын зах зээл 3.3 их наяд ам.долларт хүрч дэлхийн аялал жуулчлалын зах зээлийн 30 орчим хувийг бүрдүүлж байгаа юм. Ази, Номхон далайн бүс нутгийн соёлын олон янз байдал, байгалийн баялаг нөөц нь соёлын аялагчдын анхаарлыг илүү татдагаараа давуу талтай. НҮБ-ын аялал жуулчлалын гишүүн орноос Бүгд Найрамдах Бангладеш Улс, Бутаны Хаант Улс, Камбожийн Хаант Улс, Бүгд Найрамдах Фижи Улс, Бүгд Найрамдах | II-III улирал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Индонез Улс, Исламын Бүгд Найрамдах Иран Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс, Малайз Улс зэрэг 21 улсын 26 оролцогчид, Бүгд Найрамдах Солонгос Улсын Жежүгийн аялал жуулчлалын байгууллагын 7 төлөөлөгчид болон илтгэгч, панел хэлэлцүүлэгт оролцохоор нийт 42 олон улсын төлөөлөгчдийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Новотел зочид буудалд хүндэтгэлийн нээлтийн арга хэмжээг 200 гаруй аялал жуулчлалын байгууллагын төлөөллийг оролцуулан ёслол төгөлдөр зохион байгууллав. 2025 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд НҮБ-ын Аялал жуулчлалын форумыг Соёлын аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлага ба гол ойлголтуудыг танилцууллаа. Хаалтын арга хэмжээг Чингис хаан үндэсний музейн 5 давхарт "Мөнгөн мод" танхимд зохион байгуулав. 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хүндэт зочдыг Төв аймгийн Аргалант сумын "Монгол Номадик" жуулчны бааз дээр арга хэмжээ зохион байгуулав. | | |
| 28 | 2.6.7 | Монгол, Орос, Хятад гурван улсын "Аялал жуулчлалын сайд нарын IX удаагийн хуралдаан"-ыг Монгол Улсад зохион байгуулах<br><br>**АХ 2050-4.2.43, 4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3, 5.4** | 100.0 | Хуралдаан зохион байгуулсан эсэх | Монгол, Орос, Хятад гурван улсын аялал жуулчлалын сайд нарын VIII уулзалтад оролцсон. | Хуралдаан зохион байгуулсан байна. | Хугацаа болоогүй. | III-IV улирал | - |
| 29 | 2.6.7 | "Адал явдалт аялал жуулчлалын холбооны бүсийн уулзалт, форум"-ыг Монгол Улсад зохион байгуулах<br><br>**АХ 2050-4.2.43, 4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.3, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3, 5.4** | 200.0 | Уулзалт форум зохион байгуулсан эсэх | - | Уулзалт форум зохион байгуулсан байна. | Адал явдалт аялалын холбоотой хамтран монголын хөтөч, аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн мэргэжлийн түвшинг дээшлүүлж, олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх, Монгол Улсыг Адал явдалт аяллын шинэ чиглэл болгон таниулах маркетингийн боломжийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдол бүхий адал явдалт аялал жуулчлалын уулзалт форумыг зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангав. | II-IV улирал | 100% |
| Зорилт 2.8. Дундговь аймгийн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна. | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | - | Дундговь аймгийн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүс тогтоох<br><br>**АХ 2050-8.2.3**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.12**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3** | - | Бүс-1 | Судалгаа хийгдэж, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан. Говийн бүсийн 10 орон зай тодорхойлоод байгаа. | Аялал жуулчлалын тусгай бүс байгуулах судалгаа хийгдэж бүс тогтоосон байна. | МУИС-ийн харьяа Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэнтэй хамтран Аялал жуулчлалын бүсүүдийн байгаль, соёл, аялал жуулчлалын дэд бүтцийн нөөцийг тодорхойлох гүйцэтгэж байна. Судалгааны ажлын хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх аялал жуулчлалын бүсүүдийг тодорхойлсон. Менежментийн төлөвлөгөөг боловсруулах суурь судалгаа аялал жуулчлалыг хөгжүүлэх орон зайн шалгуур үзүүлэлтээр гарсан. Бүсчилсэн хөгжлийн үндсэний зөвлөгөөн /Хангай, Хойд, Говийн/ бүс дээр аялал жуулчлалын бүсийн орон зайг танилцуулан хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр танилцуулсан. | I-IV улирал | 50% |
| **ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | | |
| Зорилт 8. Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих | | | | | | | | | |
| 31 | 1.2.2 1 | Аялал жуулчлалын хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-1.2** | 30.0 | Үнэлгээ -1 | Аялал жуулчлалын тухай хууль 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан. | Аялал жуулчлалын хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн байна. | Аялал жуулчлалын хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. | II-IV улирал | 70% |
| 32 | 1.2.2 1 | Аялал жуулчлалын тухай хууль, дагалдан гарсан журмуудыг сурталчлах арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-1.2** | - | Бүсүүдийн зөвлөгөөнд сурталчилсан эсэх | Аялал жуулчлалын хууль батлагдсан. | Аялал жуулчлалын хууль болон дагалдах журмуудыг бүсүүдийн зөвлөгөөний үеэр сурталчилсан байна. | Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарласны хүрээнд “Tourism week-2025” арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 10-аас 14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Улаанбаатар зочид буудалд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулах хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: “Tourism week 2025” аялал жуулчлалын үндэсний чуулганы 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “Аялал жуулчлал ба бүсчилсэн хөгжил” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, салбарын бодлого, аялал жуулчлалын бүсчлэлийн талаар холбогдох төрийн байгууллага, салбарын төлөөлөл, эрдэмтэн судлаачидтай хэлэлцүүллээ. Мөн төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлогын талаар танилцуулга хийж, хууль, эрх зүйн салбар хуралдааны | I-II улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл, оюутан залуучууд, оролцогч, төлөөлөгчдөд холбогдох хууль, журмуудыг танилцуулж, сурталчлан хэлэлцүүллээ.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 64 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бүс орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх хүрээнд "Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан"-ыг Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооноос 7 бүсэд хуваарийн дагуу зохион байгуулж байна. Уг ажлын хүрээнд тус яамнаас Хангайн бүсийн салбарын "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Өвөрхангай аймагт, Хойд бүсийн салбарын "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Орхон аймагт, Говийн бүсийн салбарын "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Дундговь аймагт тус тус зохион байгуулсан. Дээрх зөвлөгөөний хүрээнд аялал жуулчлалын салбарт холбогдох хууль, журмуудыг сурталчлан танилцуулсан. | | |
| 33 | 3.7.4 | Даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хяналт тавих журмыг боловсруулж, батлуулах<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-1.2** | - | Журам -1 | - | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нарын хамтарсан тушаалаар батлуулсан байна. | Аялал жуулчлалын тухай хуулийн 14.5-т заасны дагуу холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батлуулах ажлын хүрээнд тус хорооноос хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох албан тушаалтныг мэдээллийг авч, Сайдын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалыг батлуулсан.<br>Уг ажлын хүрээнд 2025 оны 03 дугаар 31-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороонд уулзалт хийж, ажлын хэсгийн хуралд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тур оператор компаниудын оролцоо чухал болохыг онцлон, аялал жуулчлалын салбарт гарч болох эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, төрөлжүүлэх шаардлагатай талаар хэлэлцлээ. Эрсдэл болон даатгалын тухай тур оператор, тур агентуудад холбогдох мэдээллийг хүргэж, санал солилцох чиглэлээр уулзалт зохион байгуулах, аялал жуулчлалын салбарт жуулчинд тохиолдож болох эрсдэлүүдийг тодоройлон хоёр талаас танилцуулга бэлтгэн хүргүүлж, хамтарч ажиллах юм. Тус уулзалтын мөрөөр Монгол Улсад | I-II улирал | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аялсан гадаад, дотоодын жуулчдад тохиолдсон эрүүгийн хэрэг, зам тээврийн осол, зөрчил, байгалийн гамшигт үзэгдлийн улмаас учирсан амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, санхүүгийн зэрэг хохирлын мэдээллийг Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын газар, НАЖГ-аас авахаар албан бичиг хүргүүлсэн. Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй танилцан хүлээн авсан. Тус журмыг боловсруулахад мэргэжлийн холбоог хамтран ажиллаж, тур оператор, холбогдох үйлчилгээний байгууллагуудаас эрсдэлийн мэдээллийг ирүүлэх тухай албан бичиг хүргүүлэхээр төлөвлөсөн. | | |
| 34 | 3.7.1 | Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-1.2**<br>**АЖТХ-6.5** | - | Журмыг хэлэлцүүлж, батлуулсан эсэх | Журмын төслийг боловсруулсан. | Журмыг хэлэлцүүлж, батлуулсан байна. | Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг боловсруулсан. Салбарын холбогдох төлөөллүүдтэй хэлэлцүүлсэн бөгөөд ТНБД-ын хурлаар хэлэлцүүлнэ. | I-IV улирал | 100% |
| 35 | 3.7.6 | Жуулчдад зориулсан эвентийг эрэмбэлэх аргачлалыг батлуулах, хэрэгжилтийг хангах<br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-1.2**<br>**АЖТХ-21.1.4** | - | Эвентийг эрэмбэлэх аргачлалыг батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн эсэх | Эрэмбэлэх аргачлалыг боловсруулсан. | Эвентийг эрэмбэлэх аргачлалыг батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байна. | Жуулчдад зориулсан эвентийг ангилах, үнэлэх, аргачлалыг боловсруулан шалгуур үзүүлэлтийн дагуу 180 эвентийг үнэлэн Монгол Улсад 2025 онд зохион байгуулагдах соёл, аялал жуулчлал, спорт, хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн арга хэмжээний нэгдсэн цаглабарыг нийслэл, 21 аймаг, төрийн байгууллагуудын саналыг үндэслэн боловсруулж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанд танилцуулж, батлуулав. Баталсны дагуу "Мазаалай – 2025", Хөх сувд-2025, Олон улсын мөсөн сийлбэрийн уралдаан, Түмэн тэмээний баяр, Аялал жуулчлалын 7 хоног зэрэг эвентүүдийг зохион байгуулав. | I-IV улирал | 100% |
| 36 | 3.7.2 | Улсын аялал жуулчлалын бүс тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, батлуулах | - | Шалгуур үзүүлэлт боловсруулж, | Аялал жуулчлалын 7 бүсчлэл, 66 | Шалгуур үзүүлэлт боловсруулж, | Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1 дэх хэсэг, МУ-ын БХҮБ-ын 3.5, 3.3.5.2, үндэслэн "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг хангах хүрээнд бүсүүдийн нөөц, даац, онцлогт | I-IV улирал | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-1.2**<br>**АЖТХ-21.1.7** | | батлуулсан эсэх | орон зайг тодорхойлсон. | батлуулсан байна. | тулгуурлан орон нутгийн эдийн засгийг нэмэгдүүлэхүйц төлөвлөлт хийж, аялал жуулчлалын хөгжлийн орон зайн үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлалыг хийх, бүсийн зураг" хийх ажлыг МУИС-ийн харьяа Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэнтэй хамтран гүйцэтгэж байна. Аялал жуулчлалын 7 бүсчлэлд хуваан, 66 орон зайг тодорхойлж тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй тодорхойлон хийсэн. Бүсчилсэн хөгжлийн үндэсний зөвлөгөөн дээр аялал жуулчлалын бүсийн орон зайг танилцуулан хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр танилцуулга хийгдэж байна. Одоогоор "Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэнтэй" аялал жуулчлалын бүс тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах ажлын гэрээг байгуулж байна. Гэрээ байгуулагдаж санхүүжилт шийдсэнээр 66 орон зайг Засгийн тогтоолоор батлуулна. | | |
| 37 | 1.2.9 | Түүхэн аялал жуулчлалын үзэл баримтлал боловсруулахад санал<br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -1.3.6, 3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-1.2**<br>**АЖТХ-21.1.7** | - | Үзэл баримтлалд боловсруулахад анал өгсөн эсэх | Түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын үзэл баримтлал боловсруулагдсан. | Үзэл баримтлал боловсруулахад санал өгсөн байна. | Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд Хэнтий аймагт "Их хуралдай", "Монголын нууц товчоо", "Шихихутаг" цогцолборын ажил хийгдэж байгаа бөгөөд "Их хуралдай" цогцолборыг 2023 онд улсын комисс хүлээн авсан бол "Монголын нууц товчоо", "Шхихутаг" цогцолбороын ажил 90 орчим хувьтай байна. Зүүн бүсийн аялал жуулчлалын нөөц, даац, онцлогт тулгуурлан орон нутгийн эдийн засгийг нэмэгдүүлэхүйц төлөвлөлт хийх, аялал жуулчлалын хөгжлийн орон зайг тодорхойлох чиг үүрэг бүхий "Зүүн бүсийн аялал жуулчлалын"-ийн үүрэг бүхий ажлын хэсгийг 2025.03.21 ний 53 дугаар Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө батлах тухай, аялал жуулчлалын бүс байгуулах үзэл баримтлал, төлөвлөлтийн хийх МУ-ын Ерөнхий сайдын захирамж гарсан. Захирамжийн дагуу 2025оны 05дугаар сарын 02ний өдрийн А/172 дугаар Сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Хэнтий аймгийн бүс нутагт хэрэгжиж буй томоохон дэд бүтцийн төслүүд, Дорнод аймгийн хил орчмын аялал жуулчлал, Буйр нуурын усан зогсоол бүхий аялал жуулчлалын ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэлтэй тухайн газар дээр | II, III, IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нь ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд ажилласан. Дээрх ажлын дагуу дэд бүтцийн ажлын гүйцэтгэгч байгууллагуудад хугацаатай чиглэл өгөн ажиллаж байна. | | |
| 38 | 3.7.5 | Олон улсын үзэсгэлэнд оролцох шалгуур үзүүлэлт боловсруулах, батлуулах<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-1.2**<br>**АЖТХ-21.1.4** | - | Шалгуур үзүүлэлт -1 | Олон улсын аялал жуулчлалын 10 үзэсгэлэнд оролцсон. | Шалгуур үзүүлэлт боловсруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар батлуулсан байна. | Олон улсын үзэсгэлэнд оролцох шалгуур үзүүлэлтийг АЖМХ-той хэлэлцэн саналыг авч, боловсруулсан. Тус төслийг яамны газар, нэгжүүдээс санал авахаар нэгж хоорондын санал хуудас хүргүүлсэн. Хууль, эрх зүйн хэлтсээс Аялал жуулчлалын тухай хуулинд эрх олгосон заалт байхгүй байх тул төслийг дэмжих боломжгүй талаар санал ирүүлсэн. Иймд Мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн хурлаар батлуулах чиглэлийг хүргүүлэхээр төлөвлөж байна. Тус шалгуур үзүүлэлтийн дагуу олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох аж ахуйн нэгжүүдийг сонгож байна. | I-IV улирал | 100% |
| Зорилт 4. Монгол Улсыг сурталчлах ажлыг холбогдох чиг үүргийн төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах /АЖТХ-21.18/ | | | | | | | | | |
| 39 | 2.6.1<br>1 | Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцох /ITB, Let's travel, COTTM, SITF, JATA, CITM, WTM, TOP RESA, ITB Asia/<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.8** | 1.400.0 | Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсон эсэх | Монголд зочлох жилийн хүрээнд 2024 онд олон улсын аялал жуулчлалын 8-10 үзэсгэлэнд тогтмол оролцсон. | Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсон байна. | **ITB-** Тус яамнаас дэмжлэг үзүүлэн олон улсын хэмжээнд зохион байгуулагддаг томоохон аялал жуулчлалын үзэсгэлэнгийн нэг болох "ITB Berlin 2025"-д оролцлоо. Тус үзэсгэлэн нь аялал жуулчлалын салбарыг олон улсад сурталчлах, шинэ зах зээлд нэвтрэх, хөрөнгө оруулалт татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэх, зах зээлээ өргөжүүлэх болон Монгол Улсыг сурталчлах, таниулах зорилгоор оролцож, тусгай хэсгийг "Go Mongolia" брэндинг дор нэгдсэн өнгө төрхөөр тохижууллаа. Энэ жилийн үзэсгэлэнд аялал жуулчлалын 13 тур оператор компани, үүнээс 5 нь гарааны бизнес эрхлэгч оролцож, Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Б.Мандахбилэг оролцож Монгол-Германы аялал жуулчлалын хамтын ажиллагааны ач холбогдлыг онцолсон. Үзэсгэлэнгийн хүрээнд аялал жуулчлалын онцлох бүтээгдэхүүн, өв соёлыг олон улсад таниулах "Go Mongolia" сурталчилгааны өдөрлөг, аялал жуулчлалын салбарын төлөөлөгчид, олон улсын түншүүдтэй бизнес уулзалт хийх, аялал жуулчлалын боломж, шинэ бүтээгдэхүүн, хөгжлийн чиг хандлагыг танилцуулахын зэрэгцээ Чингис хаан Үндэсний музейн Хаан найрал чуулга "Их Монгол" болон "Адуу хураах дуу" зэрэг бүтээлүүд, Монгол хаадын ёслолын бүжгийг | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | толилуулж, үндэсний урлаг, өв соёлыг харуулан сурталчиллаа.<br><br>**СОТТМ-** Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Монгол Улсыг гадаад улсад сурталчлах зорилгоор БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан "СОТТМ-2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, ССАЖЗЯ-аас дэмжлэг үзүүлэн АЖБХЗГ-ын мэргэжилтэн оролцлоо. БНСУ-ын Сөүл хотод 2025 оны 06 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Korea World Travel Fair"-д оролцлоо. НАЖГ, Улаанбаатар Театр, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, МОКТА салбар холбооны 9 тур оператор компанийн 28 төлөөлөл хамтран "Go Mongolia" Үндэсний брэндийн дор жуулчдад зориулсан мэдээлэл түгээх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн сурталчлах, бизнес уулзалтууд хийсэн юм.<br><br>**SITF-** "Korea World Travel Fair" (KOTFA) нь БНСУ дахь хамгийн том олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн ба жуулчлалын нөөц боломж, өв соёлоо сурталчлан таниулах дэлхийн хэмжээний чухал талбар болдог. KOTFA нь дотоод, гадаадын албан ёсны аялал жуулчлалын байгууллагууд оролцож, ивээн тэтгэдэг БНСУ дахь цорын ганц олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн гэдгээрээ онцлогтой.<br>БНСУ-ын жуулчдын өсөлтийг хадгалах, цаашид улам нэмэгдүүлэх зорилгоор ССАЖЗЯ, НАЖГ, Улаанбаатар Театр, АЖМХ, МОКТА салбар холбооны 9 тур оператор компанийн 28 төлөөлөл хамтран "Go Mongolia" Үндэсний брэндийн дор оролцсон. Үзэсгэлэнд оролцогчид жуулчдад зориулсан мэдээлэл түгээж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн сурталчлан, бизнес уулзалтууд хийж, ардын урлаг, соёлын тоглолт зэргээр өргөн хүрээний арга хэмжээг зохион байгуулсан юм.<br><br>**Летс травел-** Монгол Улсыг сурталчлах "Go Mongolia" арга хэмжээг голлох зах зээлийн орнуудад зохион байгуулах хүрээнд ОХУ-ын Москва хотноо 2025 оны 06-р сарын 10-аас 15-ны өдөр зохион байгуулагдах | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Let's Travel" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож эхэлсэн. Энэхүү үзэсгэлэнд оролцсоноор Оросын жуулчдад Монгол Улсыг шинэ, найдвартай аяллын чиглэл болгон сурталчлах, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, тогтвортой аяллыг төлөвлөх боломж бүрдэнэ. Геополитикийн өөрчлөлт, олон улсын аяллын чиглэл хязгаарлагдсаны улмаас ОХУ-ын иргэдийн дунд шинэ, аюулгүй, ойрын чиглэлүүдэд хандсан аяллын эрэлт эрс нэмэгдэж байна. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Монголын аялал жуулчлалын холбоо бүртгэл, зохион байгуулалтыг хийж гүйцэтгэсэн. Тус үзэсгэлэнд ХишигДаймонд, Пакс Номадик, ХаппиТрип зэрэг тур операторуудын төлөөлөл, Гоёл кашмераас ноос ноолууран бүтээгдэхүүний танилцуулж, үндэсний язгуур урлагийн үзүүлбэрийг толилууллаа. Мөн ССАЖЗЯ-ны НТХ-ийн шинжээч, Сэлэнгэ аймгийн СУАЖЗГ-ын дарга нар туршлага судлахаар оролцсон. | | |
| 40 | 2.6.14 | Аялал жуулчлалын гол зах зээлийн орнуудын аяллын компаниудад Монгол улсыг таниулах, дотоодын аж ахуйн нэгжүүдтэй бизнес уулзалт "Фам тур" зохион байгуулах<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.1, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.5, 21.1.8** | 80.0 | Бизнес уулзалтыг зохион байгуулсан байх | - | Бизнес уулзалт зохион байгуулж, 5-аас доошгүй бизнесийн төлөөлөгчийг оролцуулж, "Фам тур" хийсэн байна. | Аялал жуулчлалын гол зах зээлийн орнуудын аяллын компаниудад Монгол улсыг таниулах, дотоодын аж ахуйн нэгжүүдтэй бизнес уулзалт "Фам тур" зохион байгуулах хүрээнд 2025 оны 8 дугаар сард Францын аялал жуулчлалын мэргэжилтэн Benoit Tredez Монгол Улсад зочлон, Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, бодлогыг сурталчлах, контент бүтээж Франц хэлтэн зах зээлд түгээх зорилготойгоор Монгол руу багц аялал санал болгодог Францын операторын тоог нэмэгдүүлэх, Франц жуулчдын тоог нэмэгдүүлэх, Франц зах зээлээс борлуулалтын орлого олох боломж, Монголыг "тогтвортой аяллын" чиглэлээр сурталчлах, Travel Life, ATES зэрэг байгууллагуудаар дамжуулан хүлээн зөвшөөрөгдөх үр дүн хүлээгдэж байна. Мөн хугацаанд олон улсын нэр хүндтэй эрдэмтэн судлаачид /Кэмбрижийн их сургуулийн эрдэмтэд/-ыг Монголчуудын соёл, түүхийн эх сурвалж болох Бурхан Халдун уулын газарзүйн, түүхэн, соёлын утга агуулгыг судалж, мэдрүүлэх, тухайн газартай танилцуулах фам тур зохион байгуулах төлөвлөгөөг гаргасан. | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | 2.6.7 | Монгол-Орос, Монгол-Хятадын "Аялал жуулчлалын форум"-ыг зохион байгуулах<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ -3.3.5.2, 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.5, 21.1.8** | 100.0 | Форум зохион байгуулсан эсэх | - | Форум зохион байгуулсан байна. | Хугацаа болоогүй. | III-IV улирал | - |
| 42 | 2.6.10 | Олон улсын аялал жуулчлалын арга хэмжээнд оролцох<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.8** | 55.0 | Аялал жуулчлалын арга хэмжээнд оролцож, Монгол Улсыг сурталчилсан байх | - | Арга хэмжээнд оролцож, Монгол Улсыг сурталчилсан байна. | Монгол Улсыг сурталчлах “Go Mongolia” арга хэмжээг голлох зах зээлийн орнуудад зохион байгуулах хүрээнд ОХУ-ын Москва хотноо 2025 оны 06-р сарын 10-аас 15-ны өдөр зохион байгуулагдах “Let's Travel” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож эхэлсэн.<br>Энэхүү үзэсгэлэнд оролцсоноор Оросын жуулчдад Монгол Улсыг шинэ, найдвартай аяллын чиглэл болгон сурталчлах, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, тогтвортой аяллыг төлөвлөх боломж бүрдэнэ. Геополитикийн өөрчлөлт, олон улсын аяллын чиглэл хязгаарлагдсаны улмаас ОХУ-ын иргэдийн дунд шинэ, аюулгүй, ойрын чиглэлүүдэд хандсан аяллын эрэлт эрс нэмэгдэж байна. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Монголын аялал жуулчлалын холбоо бүртгэл, зохион байгуулалтыг хийж гүйцэтгэсэн. Тус үзэсгэлэнд ХишигДаймонд, Пакс Номадик, ХаппиТрип зэрэг тур операторуудын төлөөлөл, Гоёл кашмераас ноос ноолууран бүтээгдэхүүний танилцуулж, үндэсний язгуур урлагийн үзүүлбэрийг толилууллаа. Мөн ССАЖЗЯ-ны НТХ-ийн шинжээч, Сэлэнгэ аймгийн СУАЖЗГ-ын дарга нар туршлага судлахаар оролцсон. | II-IV улирал | 100% |
| Зорилт 5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр улсын болон олон улсын хэмжээнд аялал жуулчлалын байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллах /АЖТХ-21.1.5/ | | | | | | | | | |
| 43 | 2.3.16 | Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын гишүүнчлэлийн үүргийг биелүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.5** | 150.0 | Дэлхийн аялал жуулчлалын гишүүнчлэлийн төлбөр төлсөн эсэх | 2024 оны гишүүнчлэлийн төлбөр төлсөн | ДАЖБ-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх | Монгол улс дэлхийн аялал жуулчлалын байгууллагад 1990 онд гишүүнээр элсэж өнөөг хүртэл хамтран ажиллаж ирсэн. Үүний хүрээнд 2025 оны 03 сарын 18-ны өдөр 08/748 тоот дугаартай албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын 2007 оны “Олон улсын байгууллага, гэрээ конвенцийн иттэмжит санд төлөх татвар, хандивын тухай” 60 дугаар тогтоолд заасны дагуу холбогдох байгууллагын нэхэмжлэхийг үндэслэн тухай бүр барагдуулж ирсэн ч 2021 болон 2023 оны гишүүнчлэлийн төлбөр үлдсэн байсан 33,419,0 | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | еврогийн төлбөрийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас манай яамны төрийн сангийн дансанд шилжүүлэн татсан.Энэ хүрээнд үлдэгдэл төлбөр болон 2025 оны гишүүнчлэлийн төлбөрийг төлөх талаар Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. | | |
| 44 | 2.7.11 | Монгол Улсыг сурталчлах зорилгоор Трип дот комтой хамтран ажиллах<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.5** | 385.0 | Хамтран ажилласан эсэх | - | Хамтран ажилласан байна. | Монгол Улсын засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж, дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт тавин тусгайлсан бодлого арга хэмжээг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд тус газрын цахим хуудсаар Засгийн газрын 2025 оны хуралдааны 2 дугаар тэмдэглэлээр баталгаажуулсан “Монгол Улсад 2025 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн цаглавар”-ын дагуу зохион байгуулагдаж буй арга хэмжээнүүд, олон улсын арга хэмжээ, төрөөс баримталж буй бодлого, тогтоол, шийдвэрүүдийг олон нийтэд мэдээллэн ажиллаж, мэдээллийн хандалт өндөртэй байна. | I-IV улирал | 70% |
| 45 | 1.2.8 | Монгол Улсын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө боловсруулахад олон улсын зөвлөх багтай хамтран ажиллах<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.2**<br>**ССАЖЗЯ- СТ-5.1**<br>**АЖТХ-21.1.5** | 3.700.0 | Санал хүргүүлсэн эсэх | - | Зөвлөх багтай хамтран ажиллаж, саналаа СБТГ-т хүргүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны Монгол Улсыг сурталчлах зарим арга хэмжээний тухай 125 дугаар тогтоолын дагуу Бостон Консалтинг Групптэй хамтран ажиллаж Монгол Улсын аялал жуулчлалын дунд хугацааны стратеги боловсруулах ажлын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Бостон Консалтинг Групптэй цахим уулзалт хийж, зөвлөх багаас аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг танилцуулж, хэлэлцлээ.<br>Тус стратегийн төслийг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зочид буудал, жуулчны баазуудад, 21-ний өдрүүдэд тус тус тур операторуудад цахимаар танилцуулан, хэлэлцүүллээ. Цахимаар нийт 52 зочид буудал, жуулчны бааз, 84 тур оператор компаниуд бүртгүүлж хамрагдав.<br>2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсаас гадаад улс орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад цахимаар танилцуулж, хэлэлцүүллээ.<br>Монгол улсын аялал жуулчлалын үндсэн 13 голлох зах зээл, долоон сегментэд зориулсан аялал жуулчлалын хөгжлийн саналуудыг болон стратегид тодорхойлсон 14 зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна. Тухайлбал, дэд бүтцээ хөгжүүлэх, зам, тээврийн холболтыг сайжруулах, олон улсын маркетинг сурталчилгааг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зэрэг ажлууд багтсан бөгөөд "Аялал жуулчлалын сургалтын төв"-ийн нээлтийн арга хэмжээ буюу 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр оролцогчид, гадны төлөөллүүп олон нийтэд танилцууллаа. Сайдын 2025 оны "Стратеги төлөвлөгөө батлах тухай" тушаалаар "Монголын аялал жуулчлалын стратегийг батлуулсан. | | |
| 46 | 2.6.12 | Салбарын нэгдсэн форум, арга хэмжээ зохион байгуулах<br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.11**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.5** | 378.0 | Форум -1<br>Арга хэмжээ -1<br><br>Оролцогчдын тоо | - | Салбарын нэгдсэн форум, арга хэмжээ зохион байгуулж, -с доошгүй оролцогчтой байна. | Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласны хүрээнд "Tourism week-2025" арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 10-аас 14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Улаанбаатар зочид буудалд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулах хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: "Tourism week 2025" аялал жуулчлалын үндэсний чуулганы 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр "Аялал жуулчлал ба бүсчилсэн хөгжил" сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, салбарын бодлого, аялал жуулчлалын бүсчлэлийн талаар холбогдох төрийн байгууллага, салбарын төлөөлөл, эрдэмтэн судлаачидтай хэлэлцүүллээ. Мөн төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлогын талаар танилцуулга хийсэн болно. Хууль, эрх зүй, стандарт, дэд бүтэц, байршуулах үйлчилгээний салбар хуралдаанууддад оролцож, салбарын төлөөллүүдтэй хэлэлцүүллээ. Арга хэмжээнд төрийн байгууллага,Элчин сайдын яамдуудын газрын төлөөлөл, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн төлөөллүүдийн оролцоог хангах хүрээнд холбогдох байгууллагуудад урилга илгээх ажлыг хийж гүйцэтгэв. Аялал жуулчлалын салбарын уялдаа, хамтын ажиллагааны хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтнүүдийг тус арга хэмжээнд оролцуулж, мөн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимд АЖБХЗГ-аас яамны зүгээс хэрэгжүүлж, төлөвлөж буй ажил, арга хэмжээ, холбогдох мэдээллийг танилцуулан, "Инновац ба бүтээлч байдал" сэдэвт Харвард менежментийн сургалт зохион байгуулж нийт 33 оролцогчид сертификат гардууллаа. | II, III улирал | 100% |
| 47 | 2.6.6 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороог хуралдуулах, ажлын | 50.0 | Хурлын тоо, шийдвэрийн биелэлтийн хувь | Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо | Хурлыг зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтийг | Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны 2025 оны анхдугаар хуралдаан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн БНХАУ-ын Харбин хотноо хийсэн албан айлчлалын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын | I-IV улирал | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.2**<br>**ССАЖЗЯ- СТ-5.1**<br>**АЖТХ-21.1** | | | 5 удаагийн хурал зохион байгуулж, 12 шийдвэр гаргасан. | хангаж ажилласан байна. | 14-ний өдрийн 18.00 цагт хорооны гишүүдийн төлөөлөл болон салбарын төлөөллүүд, Улсын их хурлын дөрвөн гишүүдийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулагдав. | | |
| 48 | 2.6.2<br>3 | Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.9**<br>**ССАЖЗЯ- СТ-5.1**<br>**АЖТХ-21.1.5** | АХБ-ны хөнгөлттэй зээл | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 69 хувь | Хэрэгжилтийг 85 хувьд хүргэсэн байна. | MOH3787/3788; Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх" төслийн чиг үүргийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжсэнтэй холбоотой үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах, хоорондын уялдаа холбоог хангах үүрэг бүхий төслийн Удирдах хорооны дарга болон бүрэлдэхүүнийг 2025 оны 03 дугаарын сарын 25-ны өдрийн Сайдын А/95 тоот дугаараар шинэчлэн баталсан. Мөн Төслийн захирал болон гарын үсэг зурах эрх олгох тухай тушаалыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/87 тоот дугаараар гарсан. Төсөл шилжсэнтэй холбоотой 4-5 удаагын уулзалтыг төслийн нэгжийн багтай зохион байгуулж төслийн хэрэгжилтийн явцтай танилцсан. Хэнтий аймаг дахь Түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын аяллын маршрут, бүтээгдэхүүн, үйлчилгээг Google платформд оруулах ЗҮ27 багц зөвлөх үйлчилгээний тендер сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байгаа бөгөөд 1-р шатны үнэлгээг АХБ-наас баталгаажуулсан. Төслийн "Олон нийтийн санаачилгаар төлөвлөж хэрэгжүүлэх аялал жуулчлалын жишиг арга хэмжээ, төсөлд дэмжлэг үзүүлэх" ажлын хүрээнд 2025 онд Хөвсгөл аймагт Алаг-Эрдэнэ суманд ОНОХАА1-8,9,10 буюу 3-н гэрээт ажил, Хэнтий аймгийн Дадал суманд ОНОХАА1-5 буюу 1 гэрээт ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт нийт 37.9 км авто зам, 5 зогсоолын А2 багц гэрээт ажлыг 50%-н гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Дадал сумын төвөөс "Чингис хаан" аялал жуулчлалын цогцолбор (ЧХАЖЦ) хүртэлх 1.9 км авто зам, 3-н зогсоол, цахилгаан дамжуулах шугамын барилгын А5 багц гэрээт ажлын хүрээнд 2025 оны барилга угсралтын ажлыг ССАЖЗЯ-ны 03-р сарын 26-ны өдрийн 06/1420 тоот мэдэгдлээр эхлүүлсэн. Нийт хэрэгжилтийн хувь: 73.3% Мөн 2025 оны 06 сарын 02-10 хооронд Хөвсгөл болон Хэнтий | I, II, III, IV улирал | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймагт Төслийн хэрэгжилтийн явцад хяналт хийхээр Яамны холбогдох албан тушаалтай хүмүүс газар дээр нь ажилласан. | | |
| Зорилт 6. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх /АЖТХ-21.1.2/ | | | | | | | | | |
| 49 | - | Дотоодын болон гадаадын жуулчдын аюулгүй, ая тухтай аялах, аялал жуулчлалын салбарт хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ЗГҮАХХАХТ -**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.2** | - | Арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх | Аялал жуулчлалын идэвхтэй улиралд "Жуулчин цагдаа" арга хэмжээг ажиллуулсан. | "Жуулчин цагдаа" арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | Дотоодын болон гадаадын жуулчдын аюулгүй, ая тухтай аялах чиглэлээр Сайдын 2025оны 05 дугаар сарын 02 өдрийн 08, 09 дүгээр албан даалгаврыг орон нутаг, нийслэл, аялал жуулчлалын холбоодуудад хүргүүлэн чиглэл өгсөн. Дээрх ажилтай холбоотой АЖМХ -той хамтран жуулчдад үйлчлэх хөтчийн сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 80 хөтчийг гэрчилгээжүүлсэн. Мөн жуулчин тээврийн жолооч нарын сургалт гэрчилгээжүүлэлтийг ЗТЯ-ны Авто тээврийн үндэсний төв, АЖМХ-той хамтран Улаанбаатар хотод 2 удаа , Хөвсгөл аймагт 1, Өмнөговь аймагт 1 удаа нийт 150 жолоочыг хамруулан ажилласан. Нийслэлийн аялал жуулчлалын газраас Чингис хаан нисэх буудлын чиглэлд жуулчин тээврийн нэгдсэн автобусыг жуулчны улирал эхэлсэнтэй холбогдуулан энэ оны 05 дугаар сарын 01-ээс эхлүүлэн явуулж байна. Мөн Жуулчин цагдаа “Оюутан цагдаа 2025” Гадаадын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд хэрэгцээт мэдээ, мэдээллийг түргэн шуурхай өгч, дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор хэрэгжүүлэх “Оюутан цагдаа-2025” арга хэмжээг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Оюутны холбоотой хамтран 10 дах жилдээ зохион байгуулсан. Гадаад хэлний мэдлэгтэй, 12 их дээд сургуулийн оюутан, залуучуудыг сонгон шалгаруулж, 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд ажиллуулснаар гадаадын иргэд, жуулчид гэмт халдлагад өртөж хохирох, холбогдохоос урьдчилан сэргийлсэн томоохон ажил болдог. | I-IV улирал | **100%** |
| 50 | - | Аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, аялагчдад хариуцлагатай, аюулгүй аялах дадлыг хэвшүүлэх | - | Нөлөөллийн аян зохион байгуулсан эсэх | “Ирлээ, явлаа, цэвэр”, Хямд-Амар “Монголд зочлох жил 2023” аянуудыг | Нөлөөллийн аян зохион байгуулсан байна. | МАЖХолбооноос санаачлан ССАЖЯ-тай хамтран Дотоодын болон гадаад улс оронд аялах аялал жуулчлалд хариуцлагатай аялал жуулчлалын дадал хэвшлийг түгээн дэлгэрүүлэх, орон даяар сурталчлан таниулахаар “Хариуцлагатай Монгол Аялагч- Эх Орноосоо эхлүүлцгээе” мөн “Хариуцлагатай Монгол | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **"Ирлээ, явлаа, цэвэр"** аяныг улс орон даяар өрнүүлэх<br><br>**АХ 2050-4.2.44**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.2** | | | зохион байгуулсан. | | Аялагч- Гадаадад хэрэгжүүлцгээе" "Хариуцлагатай Монгол Аялагч- ТХГН-аа хайрлая, хамгаалъя, өвлүүлье!" үндэсний хөдөлгөөнийг 2025-2026 онд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажилдаа ороод байна. Орон нутаг, аялал жуулчлалын салбарынханд жуулчны улирал эхэлж буйтай холбогдуулан холбогдох үйлчилгээний газар, байгууллагуудадаа энэхүү урианд нэгдэн нөлөөллийн аянг хэрэгжүүлэхийг чиглэл хүргүүлээд байна. Энэхүү уриан дор Хурд хамтлаг 2025 оны 06 дугаар сарын 21 нд Бусгүй тоглолтоо хийхээр бэлтгэл ажилд ороод байна. Энэхүү ажлын хүрээнд "Ирлээ, явлаа, цэвэр" аянг үргэлжлүүлэн хэрэгжүүлж "Хариуцлагатай Монгол аялагч" эх орноосоо эхлүүлцгээе уриан дор орон нутагт хэрэгжүүлж ажиллах чиглэл өгөөд байна. | | |
| 51 | - | Дотоодын аялал жулчлалын статистик үзүүлэлт тооцох аргачлалын төсөл боловсруулах<br>**АХ 2050-4.2.44**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.2** | - | Аргачлалын төсөл-1 | Аялал жуулчлалын болон байршуулах салбарын статистик тооцох аргачлал боловсруулагдсан. | Дотоодын аялал жулчлалын статистик үзүүлэлт тооцох аргачлалын төсөл боловсруулж, ҮСХ-нд хүргүүлсэн байна. | Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар аялал жуулчлалын холбоотой хамтран 2025 оны 03 дугаар сарын 12-ний өдөр Дотоодын аялал жуулчлалын статистик тооцох аргачлалын талаар хамтарсан уулзалт зохион байгууллаа. Үндэсний статистикийн хорооноос жуулчны статистик тооцох чиглэлээр энэ жил 400сая орчим төсөв тавигдсан энэхүү аргачлалыг судалгааг 21 аймагт нарийвчлан мэргэжлийн багтай хамтран хийхэд төсөв хүрэлцэхгүй тул нэмэлт дэмжлэг шаардлагатай талаар танилцуулсан. Манай яам энэ жил тухайн ажилд төсөв хувиарлагдсан болович санхүүжилт танагдсан тул, Улаанбаатар аялал жуулчлалын холбоог Үндэсний статистикийн хороотой хамтран судалгаа хийх, бидний зүгээс орон нутгийн харьяа байгууллагуудаа чиглэл хүргүүлэн хамтран ажиллах санал өгсөн. Дотоодын аялал жуулчлалын статистик үзүүлэлт тооцох аргачлалын төсөл боловсруулах судалгааны ажлыг намар жуулчны улирал дууссан хугацаанд хийх болсон. | I-IV улирал | 50% |
| 52 | 1.2.25 | Аялал жуулчлалын салбарын тулгамдаж буй асуудлыг тодорхойлох /жуулчны бааз, зочид буудал, байршуулах хэрэгсэл, хүний нөөц зэрэг/<br>**АХ 2050-4.2.43**<br>**ССАЖЗЯ- СТ-5.3**<br>**АЖТХ-21.1.2** | 150.0 | Асуудлыг тодорхойлсон байх | - | Асуудлыг тодорхойлж, салбарын бодлогод тусгах санал дүгнэлтийг танилцуулсан байна. | Аялал жуулчлалын салбарын тулгамдаж буй асуудлыг тодорхойлох ажлын хүрээнд судалгаануудыг гүйцэтгүүлэхээр ажлын даалгаврыг боловсруулсан. "Монгол улсын жуулчны бааз түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгаа", "Гадаадын жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа хийлгэх", "Жуулчдад зориулсан хөтөлбөрт үйл ажиллагааны (activities) хэрэгцээг тодруулах судалгаа", "Дотоодын аялагчдын гадаадад аялж буй судалгаа (outbound)", "Аялал жуулчлалын судалгаа 2025" улсын хэмжээний | II, III, IV улирал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах" зэрэг асуудал тодорхойлох судалгааны ажлуудын ажлын даалгавруудыг боловсруулсан. | | |
| Зорилт 7. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн удирдлагаар хангах, мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр холбогдох иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх /АЖТХ-21.1.6/ | | | | | | | | |
| 53 | - | Аялал жуулчлалын мэргэжил сурталчлах, ажлын байранд зуучлах, хүний нөөцийн эрэлтийг тодорхойлох "Job fair" зохион байгуулах<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ССАЖЗЯ- СТ-5.1**<br>**АЖТХ-21.1.1, 21.1.6** | - | Арга хэмжээ зохион байгуулсан эсэх | - | Арга хэмжээг зохион байгуулж, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг тодорхойлсон байна. | Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласны хүрээнд "Tourism week-2025" арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 10-аас 14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Улаанбаатар зочид буудалд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулах хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимд аялал жуулчлалын мэргэжлээр суралцагч, шинэ төгсөгчдөд зориулсан илтгэл танилцуулж, ажил олгогчдын уулзалт, зөвлөгөө хүргэх арга хэмжээ зохион байгуулсан. | II, IV улирал | 100% |
| 54 | - | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийн цогц бодлогыг боловсруулах<br><br>**АХ 2050-4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.4**<br>**ССАЖЗЯ- СТ-5.2**<br>**АЖТХ-21.1.1, 21.1.6** | - | Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх ажлын төсөл | Аялал жуулчлалын хүний нөөцийн нийлүүлэлтийн судалгаа хийгдсэн | Хүний нөөцийн бодлогын төсөл боловсруулсан байна. | Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хоорондын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан төслийн яриа хэлэлцээний протоколын (RD) дагуу баригдсан 5.5 тэрбум вонийн төсөвт өртөг бүхий "Аялал жуулчлалын сургалтын төв"-ийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр нээлтээ хийж, тус сургалтын төвд зочлох үйлчилгээний салбарын сургалт болон дадлагын ажлыг, жуулчин тээврийн сургалт, аяллын хөтчийн сургалт, зочлох үйлчилгээний сургалт, ресторан зоогийн газар, зөөгчийн сургалт, аялал жуулчлалын менежментийн сургалт, тогоочийн ур чадварын сургалт зэргийг зохион байгуулсан. Цаашид хэрэгжүүлэх сургалтын төвийн менежментийн төлөвлөгөөг гарган ажиллаж байгаа бөгөөд "Аялал жуулчлалын хөгжлийн төв" байгуулагдсан. | I-IV улирал | 50% |
| 55 | 2.6.2 1 | Жуулчны хөтөч-тайлбарлагчдад зориулсан нэгдсэн сан бүрдүүлэх, үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах<br><br>**АХ 2050-2.6.10, 4.2.43**<br>**ЗГҮАХХАХТ - 3.3.5.4**<br>**ССАЖЗЯ- СТ-5.2** | 100.0 | Нэгдсэн сан бүрдүүлж, үнэмлэх олгосон байх | 2024 онд 33 хүнд жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх олгосон. | Нэгдсэн сан бүрдэж, үнэмлэхтэй жуулчны хөтөч-тайлбарлагчды н тоо нэмэгдсэн байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны "Журам батлах тухай" А/656 дугаар тушаалаар батлагдсан "Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журам"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 оны нэгдүгээр улирлын Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох шалгалтын эхний үе шат буюу ур чадварын шалгалтыг Чингис хаан Үндэсний музейд | I-IV улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **АЖТХ-21.1.1, 21.1.6** | | | | | 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдөр, Монголын Үндэсний музейд 02 дугаар сарын 23-ны өдөр тус тус зохион байгуулж, нийт 73 шалгуулагч оролцлоо. АЖБХЗГ-ын мэргэжилтэн ССАЖЗЯ-ыг төлөөлөн нэгдүгээр улирлын шалгалтын комисст ажиллаж, тус комиссын хурал 2025 оны 02 дугаар 26-ны өдөр зохион байгуулагдаж, ур чадварын шалгалтын үнэлгээнд ирүүлсэн гомдол болон бусад холбогдох асуудлуудыг хэлэлцүүлэв.<br>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, мэргэжлийн судлаач, сургагч багш нарын төлөөллөөс бүрдсэн шалгалтын комиссын удирдамжийн дагуу "Жуулчны хөтөч-тайлбарлагчид мэргэжлийн үнэмлэх олгох шалгалт"-ыг Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллан 2025 оны 02 дугаар сарын 22-27-ны өдрүүдэд зохион байгуулж, шалгалтын комиссын бүрэлдэхүүнд тус нэгжийн мэргэжилтэн ажилласан болно. Жуулчны хөтөч-тайлбарлагчдын 2025 оны нэгдүгээр улирлын шалгалтад бүртгэлээ баталгаажуулсан 82 шалгуулагч оролцсоноос 46 шалгуулагч тэнцэж, 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Монголын Үндэсний музейд жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх гардуулах үйл ажиллагаа зохион байгуулагдсан. | | |
| Зорилт 8. Аялал жуулчлалын бүсийн нөөц, даацыг тогтоох, аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн тоо, байршлыг тогтоох, тэдгээрийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх /АЖТХ-21.1.7/ | | | | | | | | | |
| 56 | - | Аялал жуулчлалын бүсүүдийн байгаль, соёл, аялал жуулчлалын дэд бүтцийн нөөцийг тодорхойлох<br><br>**АХ 2050-8.2**<br>**ЗГҮАХХАХТ – 1.3, 3.3.5.4, 3.3.5.9**<br>**ССАЖЗЯ- СТ-5.5**<br>**АЖТХ-21.1.7, 21.1.11** | - | Нөөцийг тодорхойлсон эсэх | - | Нөөцийг тодорхойлсон байна. | Монгол Улсад 2024 оны 10 дугаар сарын байдлаар бид 29 мянган жуулчин хүлээн авсан. Манай улс аялал жуулчлалын глобал индексийн 3 жилийн дундаж үзүүлэлт 7.0 онооноос 4.12 буюу 58.9 хувийн түвшинд байгаа нь аялал жуулчлалын салбарын бодлогын менежментийг бүх шатанд анхаарч сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илэрхийлж байна. Аймгуудын аялал жуулчлал салбар дахь оролцоо их боловч аялал жуулчлалын хөгжилд оруулж буй хувь нэмэр, үйл ажиллагааны нөхцөл байдлыг зөвхөн жуулчдын тоогоор илэрхийлэх нь өрөөсгөл тул Дэлхийн эдийн засгийн форумын боловсруулсан олон улсын арга зүйгээр аймгуудын аялал жуулчлалын хөгжлийн индексийг тодорхойлох нь зүйтэй гэж үзэж аймгуудын аялал жуулчлалын хөгжлийн индексийг тодорхойлов. | II улирал | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
